



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

АУДИТЫН ТАЙЛАН

***Монгол Улсын 2008 оны
нэгдсэн төсвийн гүйцэтгэл***

Улаанбаатар хот

2009 оны 4 дүгээр сарын 14

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн:	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
ҮАГ-ын Нэгдүгээр газар		
Газрын захирал Ц.Батбаяр	1 Монгол Улсын 2008 оны төсвийн бүрэлдэхүүн, онцлог, тэнцэл	
Аудитын менежер Ж.Батсайхан	1.1 Монгол Улсын 2008 оны төсвийн зорилт	4
Ахлах аудитор Л.Одгэрэл А.Сүхбаатар Ц.Гэрэл	1.2 Улсын 2008 оны төсвийн бүрэлдэхүүн	4
	1.3 Монгол Улсын 2008 оны төсвийн онцлог	5
	1.4 Монгол Улсын 2008 оны төсвийн тэнцэл	5
Аудитор Д.Даваабаатар Д.Гандолгор З.Ариунзаяа	2. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл	
	2.1 Нэгдсэн төсвийн орлого	7
	2.2 Улсын төсвийн орлого	10
	2.3 Орон нутгийн төсвийн орлого	16
	2.4 Нийгмийн даатгалын сангийн орлого	17
	2.5 Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлого	18
Шинжээч Ц.Эрдэнэчулуун Л.Эрдэнэчулуун Б.Саруул Ш.Энхтайван Б.Болормаа	3. Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл	
	3.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөөний биелэлт	19
	3.2 Улсын төсвийн зарлагын төлөвлөгөөний гүйцэтгэл	20
	3.3 Орон нутгийн төсвийн зарлагын гүйцэтгэл	24
	3.4 Монгол Улсын хөгжүүлэх сангийн зарлагын гүйцэтгэл	25
	3.5 Нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэл	25
2009 оны 4 дүгээр сар	4. Зөвлөмж	26
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү: www.mnao.pmis.gov.mn	5. Хавсралт	
Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 263533 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.	6. Ì î í ã ë Öëñû í Åð° í öëé àóäèõì õû í òóø ààè	30
ХАЯГ: Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс		

Товчилсон үгийн жагсаалт

АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
АХБ	Азийн хөгжлийн банк
АТГ	Авлигатай тэмцэх газар
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
БСШУС	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
БХЯ	Батлан хамгаалах яам
ЗТХБЯ	Зам тээвэр, хот байгуулалтын яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуучлалын яам
ГХС	Гадаад хэргийн сайд
ГИХАЭА	Гадаадын иргэн, харъяатын асуудал эрхлэх алба
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕТГ	Ерөнхийлөгчийн тамгын газар
НХХС	Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн сайд
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
УИХ	Улсын Их Хурал
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
УНДЕГ	Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ҮХС	Үйлдвэр худалдааны сайд
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СС	Сангийн сайд
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТГ	Тамгын газар
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам

Ажлын үндэсний аудитын газар Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 38.1-д заасны дагуу Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2009 оны 3 дугаар сарын 25-наас 4 дүгээр сарын 20-ны өдрүүдэд аудит хийв.

Монгол Улсын 2008 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Сангийн яам Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 37.1 дэх заалтын дагуу Монгол Улсын 2008 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг танилцуулгын хамт нэгтгэж, гаргасан байна.

Үүнд дараахь мэдээллийг агуулсан байна.

- Монгол Улсын 2008 оны төсвийн гүйцэтгэлийн танилцуулга
- Монгол Улсын 2008 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд
- Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2008 оны төсвийн гүйцэтгэлийг байгууллагаар нэгтгэсэн байдал
- Засгийн газрын нөөц хөрөнгийн гүйцэтгэл
- Улсын төсвийн хуваарилагдаагүй зардлын гүйцэтгэл
- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэл

СЭЗ /хуучин нэрээр/-ийн сайдын 2003 оны 91 дүгээр тушаалаар баталсан “Улс, орон нутгийн төсвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого”-ын 1.3-д “Улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагыг мөнгөн суурьтай бүртгэлийн зарчмаар хүлээн зөвшөөрч тайлагнана” гэж заасны дагуу СЯ-ны Төрийн сангийн газраас улсын нэгдсэн төсвийг мөнгөн сууриар гүйцэтгэлийг тооцож тайлагнасан байна.

Аудитыг гүйцэтгэхдээ ажлын үндэсний аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгосны зэрэгцээ холбогдох алба тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт боловсруулав. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Монгол Улсын 2008 оны төсвийн бүрэлдэхүүн, онцлог, тэнцэл

1.1. *Монгол Улсын 2008 оны төсвийн зорилт.* Монгол Улсын 2008 оны төсвийн бодлого нь макро эдийн засгийн өсөлт болон төсвийн тогтвортой, тэнцвэрт байдлыг бататгаж, санхүүгийн үндэсний нөөц, гадаад эх үүсвэрийг оновчтой хуваарилах замаар хүн амын бодит орлого, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, бодит салбарын хөгжлийг дэмжихэд чиглэгджээ.

1.2. *Монгол Улсын 2008 оны төсвийн бүрэлдэхүүн.* Монгол Улсын нэгдсэн төсөв нь 2008 оноос эхлэн улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв гэсэн 4 хэсгээс бүрдэж байна.¹

1.3. *Хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ.* Төсвийн харилцаанд шинээр гарч буй асуудлуудыг боловсронгуй болгох, төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх зорилгоор 10 орчим хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг 9 пунктээр бууруулсан нь ажил олгогчийн татварын дарамтыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих, далд эдийн засгийн түвшинг багасгахад чиглэгдсэн байна.
- УИХ стратегийн барааны үнийг тогтворжуулах, хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор импортлосон 40.0 мянган тонн гурилын НӨАТ, гаалийн албан татварын хувь хэмжээг тэглэх шийдвэр гаргав.
- Засгийн газар 2008 оныг “Хүнсний хангамж, аюулгүй байдлын жил” болгож, энэ зорилтыг хэрэгжүүлэх 4 чиглэлийн 63 үйл ажиллагааг явуулж, энэхүү арга хэмжээг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажиллажээ.
- Хүнсний салбарт 13.2 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн хөнгөлөлт үзүүлж, 39.8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийснээр ажиллагсдын орон тоо 10.6 хувиар нэмэгдэж, хүнсний боловсруулах салбарын үйлдвэрлэл 19.1 хувиар өслөө.
- Байгаль орчныг хамгаалах, цаг агаарыг урьдчилан таамаглах чиглэлд улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 4.2 тэрбум төгрөг зарцуулжээ.
- Эрүүл мэндийн салбарын үйлчилгээг сайжруулах, эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг хангахад нийт төсвийн 12 хувийг зарцуулсан байна.
- Боловсролын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, сургалтын тав тухтай орчин бүрдүүлэх зорилгоор төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлжээ.

¹ Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны орлого, зарлагын гүйцэтгэлийг хавсралт 1, 2-т үзүүлэв.

1.4. Монгол Улсын 2008 оны төсвийн онцлог. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2008 оны гүйцэтгэлээр төсвийн нийт орлого 2,170.4 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 35.4 хувьд, төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2,466.8 тэрбум төгрөг болж, ДНБ-ий 40.2 хувьд хүрчээ.

2008 онд улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалт 2005 онтой харьцуулахад 7.8 дахин, өмнөх оныхоос даруй 1.2 дахин нэмэгджээ.

Засгийн газар, бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих ажлыг эрчимжүүлж, санхүүгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх зорилгоор Монгол Улсыг хөгжүүлэх сан болон улс, орон нутгийн төсвөөс бүс нутаг, хөдөөгийн хөгжлийг дэмжихэд хөрөнгө оруулалтаар 61.4 орчим тэрбум төгрөгийг олгож, 500.0 сая төгрөгөөс доош төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалтын санхүүжилтийг орон нутагт хуваарилах ажлыг зохион байгуулсан байна.

2008 онд Засгийн газраас төрийн байгууллагад ажиллагсдын цалин болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлж, дундаж цалинг 300 мянган төгрөгт хүргэж, тэтгэвэр, тэтгэмжийн дундаж хэмжээг 20 хувиар нэмэгдүүлж, амьжиргааны доод түвшинг 108.0 мянган төгрөгт хүргэжээ.

1.5. Монгол Улсын 2008 оны төсвийн тэнцэл. 2008 оны нэгдсэн төсвийн урсгал тэнцэл 389.8 тэрбум төгрөгийн ашигтай, нийт тэнцэл 296,4 тэрбум төгрөгийн алдагдалтай гарснаар төсвийн урсгал тэнцлийн ашиг ДНБ-ий 6.4 хувь, нийт тэнцлийн алдагдал ДНБ-ий 4.8 хувьтай тэнцэж байна.

Салбарын ДНБ-нд эзлэх хувь 2008 он



Монгол Улсын нэгдсэн төсөв ДНБ-ний 35,4 хувийг төвлөрүүлсний хувьд эдийн засаг дахь төрийн оролцооны илэрхийлэл болж байна.

Манай Улсын 2008 оны эдийн засгийн бүтцэд уул уурхайн салбар 27,8 хувь, хөдөө аж ахуйн салбар 18,8 хувь эзэлж байна.

Дээрх салбаруудын эзлэх хувь ДНБ-д өндөр байгаа нь байгаль цаг уурын хамааралтай хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гадаад зах зээлээс хамааралтай боловсруулаагүй эрдэс, түүхий эдэд тулгуурласан эдийн засгийн бүтцэд томоохон өөрчлөлт ороогүй хэвээр байгаатай холбоотой юм.

Уул уурхайн салбар давамгайлсан манай эдийн засгийн бүтэц улсын төсөвт хэрхэн нөлөөлж байгааг авч үзвэл:

Үзүүлэлт	/тэрбум төгрөгөөр/		
	2005 он	2007 он	2008 он
Нийт орлого ба тусламжийн дүн	713,1	1 880,4	2 170,4
Ашигт малтмалын нийт орлого	25,0	714,0	141,4
Ашигт малтмалын орлогын нийт орлогод эзлэх хувь	3,5	38,0	6,5
Ашигт малтмалын орлогыг хассан төсвийн нийт орлого	688,1	1 166,4	2 029,0
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	711,2	1 747,3	2 466,8
Төсвийн нийт тэнцэл	-39,3	133,1	-296,4
Ашигт малтмалын орлогыг хассан төсвийн нийт тэнцэл	-64,3	-580,8	-437,8
ДНБ-д эзлэх төсвийн алдагдал		12,7	7,1

2008 оны нийт орлогоос уул уурхайн салбараас олсон орлогыг хасвал нийт төсөв ДНБ-ний 7,1 хувьтай тэнцэх 437.8 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч байна.

Эндээс харахад манай орны төсөв уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай төсөв болж хувирсан байна. Ингэснээр манай улсын төсвийн орлогын тогтвортой байдал дэлхийн хямрал болон гадаад зах зээл дэх зарим бүтээгдэхүүний үнийн өөрчлөлтөөс ихээхэн хамааралтай болжээ.

Хийгдсэн Мийн аюулгүй 2008 ийн үйлдвэрлэлд өөрчлөлт ийг өөрчлөлтд аюулгүй аюулгүй

2.1. Нэгдсэн төсвийн орлогын талаар

Төлөвлөгөөний талаар. Монгол Улсын 2008 оны төсвийн орлогын бодлого нь төсвийн тэнцвэрт харьцааг хадгалах хэмжээнд орлогын боломжит эх үүсвэрүүдийг бүрэн дайчлах, төсвийн орлогын тогтвортой бааз суурийг өргөжүүлэх, татвар хураалтыг эрчимжүүлэх, нийгэм эдийн засгийн хөгжлийн зорилтуудыг биелүүлэхэд төсвөөс санхүүжигдэх ажиллагааг хэвийн явуулах эх үүсвэрийг бүрдүүлэхэд чиглэгджээ.

Төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулахдаа хууль эрх зүйн орчин, Засгийн газрын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бодлого, хөтөлбөр, эдийн засгийн өсөлт, гадаад, дотоод орчны өөрчлөлтийн нөлөөллийг тооцон **Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг 2008 онд 2.5 их наяд төгрөгөөр төлөвлөсөн байна.**

2008 оны төсвийн төлөвлөгөөнд эдийн засгийн бодит өсөлтийг 10.1 хувь өсгөх, татварын ачааллыг багасгах, ДНБ-д эзлэх далд эдийн засгийн хувийг 6 пунктээр бууруулахаар төлөвлөжээ.

Дээрх зорилтыг хангахын тулд татвар, гааль, ашигт малтмал, зарим барааны үнийн өсөлтийн албан татварын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулахаас гадна татварын хууль тогтоомжийг сурталчлах, татвар төлөгчийн мэдээллийн бааз суурийг өргөжүүлэх, хариуцлагыг чангатгах, татварын хяналт шалгалтыг үр дүнтэй болгох, ногдуулсан татварыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх, гаалийн бүрдүүлэлтийг олон улсын стандарт, түвшинтэй уялдуулах, гаалийн хяналтад эрсдэлийн менежментийг нэвтрүүлэх, өндөр эрсдэлтэй бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийг судалгааны үндсэн дээр зөв оновчтой шалгах, гаалийн үйл ажиллагаанд мэдээлэл технологийн ололтыг шуурхай нэвтрүүлэх, цаашид цаасгүй бүрдүүлэлт рүү шилжих бэлтгэл ажлыг хангах зэрэг олон арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

2008 оны улсын нэгдсэн төсвийн орлого нь улсын төсөв, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, Нийгмийн даатгалын сангийн орлогуудаас бүрдэж байна.

2008 оны төсвийн төлөвлөгөөг төсвийн хүрээний мэдэгдэл анх боловсруулсан санал, анх батлагдсан төлөвлөгөө, тодотгосон төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Орлогын нэр	ТХМ	УИХ-д оруулсан санал	2008 он		
				Батлагдсан төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Нийт орлого	1784.1	2403.7	2423.2	2504.9	2170.4
2	Татварын орлого	1479.4	1995.6	2080.2	2134.2	1890.9
3	Татварын бус орлого	299.8	391.4	326.4	350.8	260.2

/тэрбум төгрөгөөр/

Төсвийн төлөвлөлтийг хуулийн дагуу жил бүр ТХМ-ийг боловсруулахаас эхэлдэг. 2008 оны улсын төсвийн төслийг боловсруулахын өмнө ЗГ-аас 2007-2009 оны ТХМ-ийг УИХ-д оруулж, УИХ-аас уг мэдэгдлийг хянан зөвшөөрсөн бөгөөд үүний дагуу 2008 оны Төсвийн төсөл боловсрогдож, хуулийн хугацаанд ЗГ, УИХ-аар хэлэлцэгдэн батлагдсан байна.

УИХ-аас хянан зөвшөөрсөн ТХМ-д тусгасан төсвийн орлогыг өөрчлөн 2423,2 тэрбум төгрөгөөр баталсан боловч 2008 оны төсвийн тодотголоор 720,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлжээ

Уул уурхайн салбар 2005 онд төсвийн орлогын 17 орчим хувийг бүрдүүлж байсан бол 2008 оны төлөвлөгөөгөөр төсвийн орлогын 48 хувийг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Зэс, алтны дэлхийн зах зээлийн үнийн таамаглалыг дэвшүүлэгч олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын үнийн төсөөлөлд үндэслэн 2008 оны төсвийн орлогын төлөвлөгөөний төсөлд 1 тонн цэвэр зэсийн үнийг 6800 ам.доллараар, 1 унци алтны үнийг 690 ам. доллараар тооцсон байна.

Монгол Улсын төсвийн орлого 2008 оны төлөвлөгөөгөөр ДНБ-ний 44.0 хувийг эзэлж, 2007 оны гүйцэтгэлээс 3.8 пунктээр нэмэгджээ.

2008 онд Эрдэнэт ХХК уулын баяжуулах үйлдвэр 655.4 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тусгасан нь улсын төсвийн орлогын 23.6 хувийг эзэлж байна.

Засгийн газраас Бороо гоулд ХХК, Цайрт минерал ХХК-тай байгуулсан Тогтвортой байдлын гэрээнд татвар төлөх нэмэлт өөрчлөлт оруулж, төсөвт 83.1 тэрбум төгрөгийн орлого оруулахаар тусгажээ.

2008 оны төсвийн төлөвлөгөөнд төсвийн орлого 2007 оны гүйцэтгэлээс 619.6 сая төгрөгөөр нэмэхээр төлөвлөсний 80.0 гаруй хувийг нь татварын орлогоос олохоор төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлийн талаар. Улсын нэгдсэн төсвийн орлого 2008 оны гүйцэтгэлээр 2170.4 тэрбум төгрөгт хүрсэн нь 2003 оныхоос 3.9 дахин, 2007 оныхоос 15.4 хувиар өссөн байна.

Нэгдсэн төсвийн орлогын өсөлт, бүтцийг графикаар харуулбал:



Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 87.0 хувийг татварын орлого, 12.0 хувийг татварын бус орлого, 1.0 хувийг хөрөнгийн болон тусламжийн орлого бүрдүүлж байна.

2008 онд татварын бус орлогын эзлэх хувь буурч, харин татварын болон хөрөнгийн орлогын эзлэх хувь нэмэгдэж ирсэн хандлагатай байна.


2008 онд нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө 13,3 хувь буюу 334.6 тэрбум төгрөгөөр тасарсан байна.

Монгол Улсын татварын ачаалал			
	/сая төгрөгөөр/		
ҮЗҮҮЛЭЛТ	2004 он	2007 он	2008 он
ДНБ, оны үнээр	1 910 880,9	4 557 500,0	6 130 300,0
Нэгдсэн төсвийн татварын орлого	583 119,0	1 502 309,9	1 890 896,6
Татварын ачаалал, %	30,5	33,0	30,8

Дээрх хүснэгтээс харахад татварын ачаалал 2004 оноос хойш нэмэгдэх хандлагатай явж ирсэн байна.

2008 онд ДНБ-д эзлэх татварын орлого 30,8 хувьд хүрч 2007 оныхоос 2,2 пунктээр буурсан хэдий ч татварын ачаалал өндөр хэвээр байна. Энэ нь зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийг хэрэгжүүлж, алт, зэсийн дэлхийн зах зээлийн үнэ буурч, татвараар орох орлогын хэмжээ буурсантай холбоотой байна.

Дэлхийн санхүүгийн хямралаас шалтгаалан 2008 оны 9 дүгээр сараас эхлэн зэсийн үнэ огцом буурч, 1 тонн зэсийн үнэ 7500 ам.доллараас 6950 ам.долларт хэлбэлзэж, улмаар 10-12 сард 6379- 2770 ам.доллар болж, төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөөлжээ. Лондонгийн металлын биржийн 2008 оны зэсийн үнийн графикыг харуулав.



Тусламжийн орлогоос бусад төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнд хүрээгүй байна.²

2.2. Улсын төсвийн орлогын талаар

Улсын төсвийн орлого 2008 онд 1720.3 тэрбум төгрөг байхаар төлөвлөснөөс 1463.9 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 256.4 тэрбум төгрөгөөр тасалсан байна. /Хавсралт 1-ээс үзнэ үү/

Улсын төсвийн орлого татварын орлого, татварын бус орлого, тусламжийн орлогоос бүрддэг бөгөөд төлөвлөгөө тасалсан шалтгааныг орлогын нэр дор бүрээр тодруулав.

Татварын орлого. Татварын орлого нь орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, тусгай зориулалтын татвар, гаалийн татвар, бусад татвар, төлбөр хураамжуудаас бүрдэх бөгөөд эдгээр татварын орлогоор 2008 онд улсын төсөвт 1279.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 1126.2 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 153.5 тэрбум төгрөгөөр тасалжээ.

- *Орлогын албан татвар.* Орлогын албан татвараар улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Сангийн яамны Төсвийн бодлого зохицуулалтын газрын Орлогын хэлтэс төлөвлөдөг бөгөөд урьд оны гүйцэтгэлд суурилан тухайн жилд нэмэгдэх үйлдвэрлэлийн өсөлт, валютын ханшийн өсөлт болон бусад холбогдох нөлөөллийг тооцон төлөвлөжээ. Орлогын албан татварын төлөвлөгөөний гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр авч үзвэл:

- *Хувь хүний орлогын албан татвар.* 2008 онд хувь хүний орлогын албан татварыг ТХМ-ээс 8.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөсөн нь төрийн албан хаагч, төсөвт байгууллагын ажиллагсдын цалинг 20.0 хувиар нэмэгдүүлснээс улсын төсөвт орох орлогын хэмжээг тооцжээ. Хувь хүний орлогын албан татварын тухай шинэчилсэн хуульд шинээр орон сууц худалдан авсан, оюутны төлбөр төлсөн иргэд татварын чөлөөлөлт эдлэхээр тусгасны дагуу буцаан олгох татварын чөлөөлөлтийг тусгасан байна.

² төлөвлөгөө тасалсан шалтгааныг татварын орлого бүрээр нарийвчлан тусгасан болно.

Хувь хүний албан татварын орлого 10.2 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь хувь хүний орлогын албан татварын хуулийн шинэчлэл нөлөөлсөн, татвар төлөгчийн тоо нэмэгдсэн, татварын бааз суурь өргөжсөн, ажиллагсдын цалингийн хэмжээ нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

- **Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар. 2008 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоор улсын төсөвт 327.3 тэрбум төгрөг оруулахаас 253.9 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 74.0 тэрбум төгрөгөөр тасалжээ.**

Зэсийн дэлхийн зах зээлийн үнийн бууралтаас хамаарч “Эрдэнэт” ХХК аж ахуйн нэгжийн албан татварын орлогыг 19.2 тэрбум төгрөгөөр тасалсан, Засгийн газраас “Бороо гоулд” ХХК, “Цайрт Минерал” ХХК-тай байгуулсан тогтвортой байдлын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулснаар ахуйн нэгжийн албан татварын орлого 68.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхээр төлөвлөсөн боловч 38.0 тэрбум төгрөгөөр дутуу орлого оруулжээ.

2008 онд Дорнод аймгийн “Улааны” цайр, хар тугалганы холимог металлын орд, Хэнтий аймгийн “Баргилтын овоо”, “Дөрвөлжин”-гийн төмрийн хүрдийн орд, Дундговь аймгийн “Төмөртэй”, “Эрээний” хүдрийн орд, Сүхбаатар аймгийн “Эрвэн хошууны овоо”-ны төмрийн хүдрийн ордыг ашиглалтад оруулахаар тооцож, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлогоор 10.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон боловч дээрх үйлдвэрүүд ашиглалтад ороогүй нь төлөвлөгөөний биелэлтэд сөргөөр нөлөөлсөн байна.

Мөн “Эрдмин” ХХК 5.6 тэрбум төгрөгөөр, “Мобиком” ХХК 3.4 тэрбум төгрөгөөр, “Скайтел” ХХК 1,2 тэрбум төгрөгөөр, “Шим технолоджи” ХХК 3.0 тэрбум төгрөгөөр, “Худалдаа хөгжлийн банк” 1.9 тэрбум төгрөгөөр, “Монголросцветмет нэгдэл” 1.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгөөг тус тус тасалсан байна.

- **Нэмэгдсэн өртгийн албан татвар. 2008 онд нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор улсын төсөвт 377.5 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр тусгажээ.** Нэмэгдсэн өртгийн албан татварын орлогоор улсын төсөвт 338.3 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 39.2 тэрбум төгрөгөөр тасалсны 36.7 тэрбум төгрөг нь импортын нэмэгдсэн өртгийн албан татварын тасалдал байна.

Дэлхийн зах зээл дэх өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт, нийлүүлэлтийн хомсдол гэх мэт гадаад хүчин зүйлсийн нөлөөллөөр дотоодын зах зээл дээр бий болсон үнийн огцом өсөлтийг саармагжуулах, дотоодын боломжит үйлдвэрлэлээр хэрэгцээгээ хангах үйл ажиллагааг дэмжих арга хэмжээг УИХ болон Засгийн газраас авч хэрэгжүүлжээ.

Импортоор оруулж ирж байгаа хөдөө аж ахуйн зориулалттай шинэ трактор, комбайн, машин механизм, гурилын үйлдвэрийн болон усалгааны тоног төхөөрөмж, бордоо, ургамал хамгааллын бодис, импортын хүнсний буудай болон 40.0 мянган тонн буудайг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлж, импортын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний гаалийн татварыг “0” хувь, автобензин, дизелийн түлшний нэмэгдсэн өртгийн албан татвар, онцгой албан татвар, гаалийн албан татварыг тус тус “0” хувьтай тэнцүү

байхаар хуульчилсан бөгөөд 2008 онд дээрх хуулийн өөрчлөлтийн дагуу нийт 85.9 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт хийгдсэн байна.

- *Онцгой албан татварын орлого.* Онцгой албан татвараар 2008 онд 193.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт оруулахаар төлөвлөсөн нь 2007 оны гүйцэтгэлээс 59.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн боловч төлөвлөгөөг 14.7 тэрбум төгрөгөөр тасалжээ.

Нийслэлийн Багануур дүүрэгт гарсан архины хордлогын улмаас бүх төрлийн архи, спирт үйлдвэрлэгчдийн үйл ажиллагааг нэг сараар зогсоосны улмаас дотоодын архины онцгой албан татварын орлого 11.9 тэрбум төгрөгөөр тасарсан нь төлөвлөгөөний биелэлтэд нөлөөлөх гол шалтгаан болжээ.

- *Тусгай зориулалтын орлого.* Энэ орлого автобензин, дизелийн түлшний албан татварын орлогоос бүрдэх бөгөөд 2008 онд 783.3 мянган тонн нефть бүтээгдэхүүн импортлож, автобензин, дизелийн түлшний албан татвараар улсын төсөвт 9.0 тэрбум төгрөгийн орлого оруулахаар төлөвлөсөн боловч төлөвлөсөн томоохон бүтээн байгуулалтын ажлууд эхлээгүй, импортоор орж ирэх нефть бүтээгдэхүүний хэмжээ 80.0 мянган тонноор багассанаас шалтгаалан 1.1 тэрбум төгрөгөөр тасарчээ.

- *Гаалийн татварын орлого.* 2008 онд улсын төсөвт төвлөрөх импортын барааны гаалийн татварыг 2007 оны гүйцэтгэлээс 52.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж төлөвлөжээ. Уул уурхайн салбарын хурдацтай хөгжил, Гаалийн тухай, Гаалийн тарифын тухай хуулийн шинэчлэлийн дагуу гаалийн татварын хөнгөлөлт чөлөөлөлтийг бууруулан нийт импортод эзлэх татвартай импортын хэмжээг 87.0 хувьд хүргэхээр төлөвлөсөн нь биелсэн байна.

- *Импортын гаалийн татвар.* Импортын гаалийн татварын орлого 16.4 тэрбум төгрөгөөр тасарсан байна. 2008 оны эхний хагас жилийн нийт импортын өсөлтийг өмнөх онтой харьцуулахад 60 гаруй хувьтай байсан бол 2008 оны сүүлийн саруудад 47 орчим хувь болтлоо огцом буурсан нь гаалийн орлогын төлөвлөгөө тасрахад нөлөөлжээ. Мөн 2008 онд импортын зарим барааны татварыг тэглэх, чөлөөлөх тухай хууль тогтоомж гарсан бөгөөд үүнтэй холбоотойгоор гаалийн албан татвараар 20.9 тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 49.8 тэрбум төгрөг, онцгой албан татвараар 15.2 тэрбум төгрөгийн, нийт 85.9 тэрбум төгрөгийн орлогыг чөлөөлсөн нь гаалийн орлого төлөвлөсөн хэмжээнээс буурахад гол нөлөө үзүүлсэн байна.

- *Экспортын гаалийн татвар.* 2008 онд экспортын гаалийн татварыг 11.0 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. Манай улсын хувьд ямааны бохир ноолуур, тэмээний ноос, бөөрөнхий мод, модон материалаас голчлон экспортын татвар төвлөрдөг бөгөөд энэ татварын 97.0 орчим хувийг ямааны ноолуураас бүрдүүлэхээр төлөвлөсөн боловч дэлхийн санхүүгийн хямрал, ноолуурын үнийн бууралт, экспортлосон самнасан ноолуурын хэмжээ 218 тонноор буурснаас шалтгаалж улсын төсөвт оруулах орлогыг 2.2 тэрбум төгрөгөөр тасалсан байна.

- *Бусад татвар (төлбөр, хураамж).* Бусад татвар, төлбөр, хураамжийн орлого нь улсын тэмдэгтийн хураамж, ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр, улсын хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр, агнуурын нөөц ашигласны төлбөр, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс бүрдэх бөгөөд 2008 онд бусад татварын орлогоор 126.6 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээс 105.6 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 21.0 тэрбум төгрөгөөр тасалжээ.

- *Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр.* Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийн орлогыг Нэгдсэн төсвийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн дагуу улс, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд салган тусгажээ.

Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын гаргасан тусгай зөвшөөрлийн мэдээлэлд үндэслэн тусгай зөвшөөрөл олгогдсон талбайн цуцлагдсан, дуусвар болсон, талбайг буцаан олгосон зэрэг эрсдэлийг тооцон төлөх төлбөрийн хэмжээг тогтоон төлөвлөсний үр дүнд улсын төсвийн орлого биелсэн байна.

- *Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр.* Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн орлого 467.2 сая төгрөг буюу 8,5 хувиар тасарсан. Төсвийн тодотголоор нэмэгдсэн орлогыг биелүүлэхээр зарим аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулсан боловч төлөвлөгөөг биелүүлэх хугацаанаас хамаарч ханган биелүүлээгүй байна.

- *Агнуурын нөөц ашигласны төлбөр.* Агнуурын нөөц ашигласны төлбөрийн орлогыг 891.9 сая төгрөгөөр тасалсан нь БОАЖЯ-наас 300 идлэг шонхор шувуу Саудын Араб, Кувейт, Катар улсад гаргахаар гэрээ байгуулж, байгаль цаг уурын дулаарал, шонхор шувууны нягтшил, тоо, шилжих хөдөлгөөний байдлаас шалтгаалан 60 шонхор шувуу дутуу нийлүүлсэнтэй холбоотой байна.

- *Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр.* Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөр улсын төсөвт оруулах орлогыг 19.1 тэрбум төгрөгөөр тасалсан нь дэлхийн зах зээл дээрх зэсийн үнэ буурч Эрдэнэт ХХК-ийн борлуулалтын орлого багассанаас шалтгаалжээ.

Татварын бус орлого. Татварын бус орлого ногдол ашиг, хүү, торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, түрээсийн орлого, газрын тосны орлого, навигацийн орлого, Монгол банкны ашиг, бусад орлогоос бүрдэж байгаа бөгөөд эдгээр орлогоор улсын төсөвт 331.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас 238.5 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 92.7 тэрбум төгрөгөөр тасалжээ.

- *Ногдол ашиг.* Ногдол ашгийн төлөвлөгөөг тасалсан гол шалтгаан нь Эрдэнэт ХХК 2007 оны ногдол ашиг 109.8 тэрбум төгрөгийг зэсийн үнийн бууралт, дэлхийн санхүүгийн хямралаас болж төлбөрийн чадвар муудсан шалтгаанаар төсөвт төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

2007 оны санхүүгийн тайланд үндэслэн ногдол ашгаар “Эрдэнэт” ХХК-аас 109.8 тэрбум төгрөг, “Улаанбаатар төмөрзам” хувь нийлүүлсэн нийгэмлэгээс

806.8 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр 2008 оны төсвийн тухай хуулиар хуульчлан баталсан байна. Эдгээр байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар “Эрдэнэт” ХХК-ийн ногдол ашгийг 25.3 тэрбум төгрөгөөр бууруулж 84.5 тэрбум төгрөгийг, “Улаанбаатар төмөрзам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн ногдол ашгийг 155.7 сая төгрөгөөр бууруулж 651.1 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр баталжээ.

Эдгээр байгууллагад Монгол Улсын төрийг төлөөлж байгаа Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хуулиар тогтоосон ногдол ашгийг хамгаалж чадаагүй нь төлөөллийнхөө үүргийг зохих ёсоор гүйцэтгээгүйг харуулж байна.

“Улаанбаатар төмөрзам” нийгэмлэг 574.2 сая төгрөгийг төсөвт төлж, “Эрдэнэт” ХХК ногдол ашгийг төсөвт төлөөгүй байна. Сангийн яам “Эрдэнэт” ХХК-ийн удирдлагын хооронд 2008 онд улсын төсөвт төвлөрүүлэх 84.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг эхний хагас жилд багтаан төлөхөөр тохиролцсон хуваарийн дагуу 2009 оны 3 дугаар сард 20.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийг төлсөн байна.

- *Газрын тосны орлого.* Газрын тосны орлого 211.0 сая төгрөгөөр тасарсанд дэлхийн зах зээлийн газрын тосны үнэ 2008 оны 8 дугаар сараас 2 дахин буурсан нь нөлөөлсөн боловч гол шалтгаан нь төмөр замын саатлын улмаас Зүүнбаянд газрын тосны олборлолт хийж байгаа “Доншен” компанийн газрын тосны экспорт 2008 оны 6 дугаар сараас зогссоноос болжээ.

- *Навигацийн орлого.* Сангийн яам болон ИНЕГ-ын хооронд байгуулсан гэрээний дагуу АХБ-наас авсан зээлийн өр, хүүд төлсөн төлбөрийг оруулж тооцвол Навигацийн орлого 26.5 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, төлөвлөгөөг 4.5 тэрбум төгрөгөөр тасалсан дүн гарч байна.

ИНЕГ нийтдээ 69.7 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан бөгөөд зардалд валютын ханшийн өөрчлөлт, шатахууны үнийн өсөлт нөлөөлсөн боловч батлагдсан төсвийг 11.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлжээ.

Удирдлагын хариуцлагагүй үйл ажиллагаанаас болж улсын төсөвт дутуу төвлөрүүлсэн 4.5 тэрбум төгрөгийн орлогыг нөхөж эхний хагас жилд багтаан төлөх ҮАГ-ын албан шаардлага өгч, аудитын явцад 2.0 тэрбум төгрөгийг барагдуулав.

- *Монголбанкны ашиг.* 2007 онд 7.1 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, энэ ашгаас улсын төсөвт 5.0 тэрбум төгрөгийг ногдол ашиг хэлбэрээр оруулахаар 2008 оны Төсвийн тухай хуулиар баталсан байна.

Монголбанк дээрх ашгийг улсын төсөвт оруулаагүй байна. Монголбанкнаас “Монголбанкны 2007 оны санхүүгийн тайланг олон улсын хөндлөнгийн аудитын “Эрнст энд Янг” компаниар баталгаажуулжээ.

Монголбанкны 2007 оны үр дүнг актив, пассивыг дахин үнэлэхэд гарсан ханшийн өөрчлөлтийн цэвэр зөрүүгээс үүссэн бодит бус ашиг гэж дүгнэсэн тул Төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 37.4-т “Актив, пассивыг дахин үнэлэхэд гарсан үнэлгээний цэвэр зөрүү болон Монголбанкнаас гадаад валютын улсын нөөцийг ашиглаж хийсэн хөрөнгө оруулалтын орлогыг Монголбанкны цэвэр

орлогын тооцоонд хамруулахгүй” гэсэн заалтын дагуу орлогод тооцохгүй юм. Иймд Монголбанкны 2007 оны үйл ажиллагааны үр дүнгээр улсын төсөвт шилжүүлэх цэвэр орлого байхгүй болохыг уламжилъя” гэсэн тайлбар өгч байна.

- *Түрээсийн орлого.* 2008 онд түрээсийн орлогоор улсын төсөвт 665.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 282.3 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 383.2 сая төгрөгөөр тасалжээ. Япон улсын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Замын-Үүдэд баригдсан ачиж, буулгах байгууламжийг ашигласны төлбөрийг “Улаанбаатар төмөрзам” хувь нийлүүлсэн нийгэмлэг төлөөгүйгээтэй холбоотой байна.

Уг байгууламжийг “Улаанбаатар төмөрзам” хувь нийлүүлсэн нийгэмлэг ашиглаж байгаа бөгөөд түрээсийн гэрээ байгуулж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын дутуу 385.7 сая төгрөгийг барагдуулах талаар Төрийн өмчийн хороо, холбогдох байгууллагууд удаа дараа шийдвэр гаргасан боловч Төлөөлөн удирдах зөвлөл шийдвэрлэнэ гэдэг шалтгаар Улаанбаатар төмөрзам нийгэмлэг түрээсийн гэрээ байгуулж, төлбөрийг төлөөгүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг мөрдөж ажиллана гэдэг шалтгаанаар Монгол Улсын хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхгүй байх явдал хамтарсан үйлдвэрүүдэд гарч байна.

- *Бусад орлого.* Бусад орлогод төрийн байгууллагуудын үйлчилгээний орлогын зардлаас давсан 20.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээс 15.7 тэрбум төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөг 4.4 тэрбум төгрөгөөр тасалсан байна. Төлөвлөгөө тасалсан байгууллагуудыг хүснэгтээр харуулбал:

1	Байгууллагын нэр	2008 он			Ø алтгаан
		төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	
1	ТӨХ /хувьчлалын орлого/	4250,0	3452,7	-797,3	ТӨХ Автоимпекс ХК-ийн төрийн мэдлийн 51 хувийг хувьчлахдаа төсөвт төлөх өрийн асуудлыг шийдвэрлээгүйгээс уг хувьчлал хүчингүй болж, худалдан авсан хувьчлалын орлого 2.0 тэрбум төгрөгийг буцаасан байна.
2	Санхүүгийн зохицуулах хороо	415.0		-415.0	Төсөвт ийм хэмжээний орлого төвлөрүүлэх боломж байхгүй гэж СЗХ тайлбараа ирүүлсэн
3	БХБНААҮТөв	225.1	175.1	-50.0	50.0 сая төгрөгийг аудитын явцад барагдуулсан.
4	ХХҮТөв	98.9		-98.9	Тодорхой шалтгаангүй, аудитын явцад барагдуулсан
5	УМХГ	1360.0	996.2	-363.8	1200.0 сая төгрөгийн орлого олсон бөгөөд 20 хувийг өөрийн орлогоор тооцон үлдэгдэл 69.4 сая төгрөгийг аудитын явцад барагдуулсан
6	ГИХАЭА	906.9	408.8	-498.1	Орлого буурсан, орон тоо нэмэгдсэн учир орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй
7	Усны хэмнэлтийн төв	355.3	72.0	-283.3	Тус төвийн үйл ажиллагааны зардлыг хасаад төсөвт төвлөрүүлэх орлогоос 120.0 сая төгрөгийн орлого дутуу төвлөрүүлсэн нь Эрдэнэт ХХК, Монголросцветмет ХХК-иудын өр бөгөөд эдгээр компаниуд дээрх орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тусламжийн орлого. Нийгмийн даатгалын сангаас улсын эмнэлгүүдэд олгосон санхүүжилт, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгө, гадаадын донор орон, олон улсын байгууллагын буцалтгүй тусламжийн хөрөнгийн орлогоос бүрдэх бөгөөд 2008 онд урсгал тусламжийн орлого 109,4 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 99,2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч,

төлөвлөгөө 10,2 тэрбум төгрөгөөр тасарсан нь Өмнөговь аймаг 2,1 тэрбум төгрөгөөр, Сүхбаатар аймаг 2,9 тэрбум төгрөгөөр, Орхон аймаг 5,7 тэрбум төгрөгөөр улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл нь мөнгөн сууриар илэрхийлэгддэг учир 2008 онд Засгийн газрын шугамаар гадаадын хандивлагч улс, олон улсын тусламжийн байгууллагуудтай байгуулсан гэрээний дагуу 71.9 тэрбум төгрөгийн тусламжийн бараа, машин тоног төхөөрөмжийг төсвийн гүйцэтгэлд тооцох боломжгүй байна.

Тусламжийн хөрөнгийг хүлээн авч, бүртгэлд тусгасан байдлыг шалгахад БОАЖЯ-нд хэрэгжиж байгаа төслүүдийг дансанд бүртгэн ТЕЗ-ийн төсвийн багцын тайлангийн төсөл, сангийн орлогод тусгасан байна. Харин ХХААХҮЯ улаанбуудайгаас бусад хөрөнгийг хүлээн авч, тайлан бүртгэлд тусгасан эсэх нь тодорхой бус байна.

2.3. Орон нутгийн төсвийн орлогын талаар

- *Орон нутгийн төсвийн орлого.* Орон нутгийн төсвийн орлого татварын, татварын бус, хөрөнгийн, тусламжийн орлогоос бүрдэх бөгөөд 207.6 тэрбум төгрөгийн орлого олохоос 207.8 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөө 184.0 сая төгрөгөөр давуулж биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Орлогын нэр, төрөл	төлөвлөгөө	2008 он	
		гүйцэтгэл	зөрүү
<i>Нийт орлого, тусламжийн дүн</i>	207,646.40	207,830.50	184.10
1. <i>Татварын орлого</i>	120,690.40	120,727.80	37.40
1.1. <i>Орлогын албан татвар</i>	11,224.20	14,877.00	3,652.80
1.2. <i>Өмчийн албан татвар</i>	8,737.70	9,199.30	461.60
1.3. <i>Тусгай зориулалтын орлого</i>	7,416.30	7,609.90	193.60
1.4. <i>Бусад татвар</i>	93,312.20	89,041.60	(4,270.60)
2. <i>Татварын бус орлого</i>	19,459.40	20,807.50	1,348.10
3. <i>Хөрөнгийн орлого</i>	7,308.70	8,537.80	1,229.10
4. <i>Тусламжийн орлого</i>	57,757.40	57,757.40	-
5. <i>Төсвийн үлдэгдэл</i>	2,430.50		(2,430.50)

2008 оны аймаг, нийслэлийн төсвийн гүйцэтгэлд орон нутгийн хөгжлийн сангийн 4.5 тэрбум төгрөгийн орлого тусгагдаагүй байна.

Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө тасалсан аймгуудыг доорх хүснэгтээр харуулав:

1	Аймгийн нэр	төлөвлөгөө	2008 он	
			гүйцэтгэл	зөрүү
1	Булган	4,763.0	4,560.1	(202.9)
2	Говь-Алтай	4,980.9	4,978.1	(2.8)
3	Дорнод	4,437.8	4,212.1	(225.7)
4	Өвөрхангай	5,363.2	5,268.3	(94.9)
5	Өмнөговь	16,216.8	13,671.7	(2,545.1)

6	Сүхбаатар	4,213.9	3,890.3	(323.6)
7	Орхон	35,177.9	31,114.9	(4,063.0)

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлд аймаг, нийслэлийн Аудитын газар аудит хийж, дүгнэлт гаргасан юм.

2.4. Нийгмийн даатгалын сангийн орлогын талаар

• *Нийгмийн даатгалын сангийн орлого.* Нийгмийн даатгалын сангийн 2008 оны санхүүгийн тайлангаар 2007 оноос ажил олгогч 2.2 мянгаар нэмэгдэж 19.8 мянга, даатгуулагч иргэн 143.3 мянгаар нэмэгдэж 2296.2 мянга болж, даатгалд хамрагсдын хүрээ нэмэгдсэн байна.

Даатгуулагчдын тоог хүснэгтээр харуулбал:

(мянган. хүнээр)				
1	Даатгуулагчид	2007 он	2008 он	зөрүү
1	Аж ахуйн нэгж байгууллагад ажиллагсад	484.8	539.7	11.3
2	Нийгмийн даатгалын сайн дурын даатгуулагчид	51.1	62.5	22.3
3	Эрүүл мэндийн сайн дурын болон заавал даатгуулагчид	321.5	340.8	6.0
4	Эрүүл мэндийг төрөөс хариуцах даатгуулагчид	1295.5	1353.2	4.4
дүн		2152.9	2296.2	143.3

Нийгмийн даатгалын сан 2008 онд 297.9 тэрбум төгрөгийн орлого оруулахаас 284.9 тэрбум төгрөгийн орлого олж, төлөвлөгөөг 13.0 тэрбум төгрөгөөр тасалжээ. Төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

/сая төгрөгөөр/				
1	Даатгалын орлого	2008 он төлөвлөгөө	2008 он гүйцэтгэл	зөрүү
1	Тэтгэврийн	190,775.7	182,486.8	(8,288.9)
2	Тэтгэмжийн	13,721.2	17,011.5	3,290.3
3	Эрүүл мэндийн	67,473.0	61,988.0	(5,485.0)
4	ҮОМШӨ-ий	12,536.4	9,467.5	(3,068.9)
5	Ажилгүйдлийн	13,389.8	13,976.2	586.4
дүн		297,896.1	284,930.0	(12,966.1)

2008 онд нийгмийн даатгалын сангийн орлого тасарсан нь Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт орж ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн хувь 19.0 байсныг 9 пунктээр бууруулж 10 хувь болгосон, санхүүгийн хямралын хүндрэлээс болж арилжааны банкууд барилгын салбарт олгох зээлийг зогсоосон, зэсийн үнийн бууралтаас Эрдэнэт ХХК-д санхүүгийн хүндрэл үүсч даатгалын шимтгэлийн орлогыг төлөөгүйгээс шалтгаалжээ.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 12.3-т “Нийгмийн даатгалын тодорхой төрлийн санд улсын төсвөөс энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө үүссэн үүргийн дагуу тэтгэвэр, тэтгэмжид олгох хөрөнгийг жил бүр төсвийн тухай хуулиар тогтооно”, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 5-д “цэргийн тэтгэвэр тэтгэмжийг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэсэн

заалтын дагуу улсын төсвөөс авах авлага 162.2 тэрбум төгрөг, нэрийн дансны үлдэгдэл 416.7 тэрбум төгрөгийг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулах зөвлөмжийг өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн юм.

2008 онд УИХ-ын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны Байнгын хорооны 4 дүгээр тогтоол, Засгийн газрын 139 дүгээр тогтоол гарч, эдгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 146/45, 322/101 дүгээр тушаалаар тэтгэврийн нэрийн дансны үлдэгдэл, улсын төсвөөс нийгмийн даатгалын санд олгох нийт татаас, төр хариуцах санхүүжилтийн хэмжээг тогтоох ажлын хэсгийг байгуулсан байна.

Ажлын хэсэг улсын төсвөөс нийгмийн даатгалын сангийн авлагыг 357.5 тэрбум төгрөгөөр, нэрийн дансны үлдэгдлийг 1766.9 тэрбум төгрөгөөр тогтоосон боловч Засгийн газар тооцоог баталгаажуулаагүй байна.

2005 онд Нийгмийн даатгалын сангийн харилцах дансыг төв болон орон нутгийн төрийн санд байршуулж, хамтран ажиллах гэрээг Сангийн яам, УНДЕГ-ын хооронд байгуулж, уг гэрээнд нийгмийн даатгалын сангийн харилцах дансны дундаж үлдэгдэлд жилийн 0.5 хувийн хүү олгохоор тусгажээ.

Энэ гэрээ хэрэгжээгүй бөгөөд 2005-2008 оны төрийн санд байршуулсан нийгмийн даатгалын сангийн үлдэгдэлд олгох хүүгийн орлогын тооцоог нийлж баталгаажуулаагүй байна.

2.5. Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлогын талаар

• *Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлого.* Монгол Улсыг хөгжүүлэх сангийн орлогын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

1	Орлогын нэр	төлөвлөгөө	/сая төгрөгөөр/	
			2008 он гүйцэтгэл	зөрүү
1	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	463,605.1	384,847.3	(78,757.8)
2	Улсын төсвийн ашиг	128,606.0	28,600.0	(100,006.0)
3	Эрсдлийн сангийн зарцуулагдаагүй хөрөнгө	7,650.0	7,650.0	
4	Хүүгийн орлого	217.9	859.1	641.2
5	Бусад		3,659.5	3,659.5
	ДҮН	600,079.0	425,615.9	(174,463.1)

• *Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар.* Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын орлого 78.7 тэрбум төгрөгөөр тасарсан нь зэсийн үнэ буурснаас Эрдэнэт ХХК-ийн төсөвт төвлөрүүлэх зэсийн үнийн өсөлтийн албан татвар 37.7 тэрбум төгрөгөөр тасарсан, Алтан дорнод ХХК 38.6 тэрбум төгрөгийн алтны үнийн өсөлтийн албан татварыг төлөөгүйгээс шалтгаалжээ.

• *Улсын төсвийн ашиг.* 2007 оны улсын төсвийн ашиг 128.6 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээс төсвийн хүндрэлээс шалтгаалан 100.0 тэрбум төгрөгийг санхүүжүүлээгүй бөгөөд Төрийн сангийн санхүүгийн тайланд авлагаар тусгажээ.

Годдод. Улсын нэгдсэн төсвийн 2008 оны зарлагын төлөвлөгөө

3.1. Улсын нэгдсэн төсвийн зарлагын төлөвлөгөөний биелэлт

Төлөвлөгөөний биелэлт. Нийгмийн хамгааллын арга хэмжээний биелэлтийг хангах, үнэ, тарифын өөрчлөлтийг тусгах, Мянганы хөгжлийн зорилтууд, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, ЗГ-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулан нийт зарлага ба цэвэр зээлийн дүнг 2,5 их наяд төгрөгөөр баталсан нь 2007 оны гүйцэтгэлээс 1.4 дахин нэмэгджээ.

Үзүүлэлт	/тэрбум төгрөгөөр/				
	2004	2005	2006	2007	2008
ДНБ, оны үнээр	1 910,9	2 779,6	3 715,0	4 557,5	6 130,3
Нэгдсэн төсвийн нийт зарлага	752,5	764,6	1 237,0	1 747,3	2 466,8
Урсгал зардал	538,7	600,3	982,3	1 367,7	1 761,2
Нэгдсэн төсвийн нийт орлого	713,1	837,8	1 360,4	1 880,4	2 170,3
ДНБ-д төсвийн нийт зарлагын эзлэх хувь	39,4	27,5	33,3	38,3	40,2
ДНБ-ний өсөлт, 2004=100		145,5	194,4	238,5	320,8
Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлт, 2004=100		101,6	164,4	232,2	327,8
Урсгал зардлын өсөлт, 2004=100		111,4	182,3	253,9	326,9
ДНБ-ний жил бүрийн өсөлт, %		145,5	133,7	122,7	134,5
Нэгдсэн төсвийн нийт зарлагын жил бүрийн өсөлт, %		101,6	161,8	141,3	141,2
Урсгал зардлын жил бүрийн өсөлт, %		111,4	163,6	139,2	128,8

Дээрх хүснэгтээс харахад, 2008 онд ДНБ оны үнээрээ 3,2 дахин нэмэгдсэн байхад нэгдсэн төсвийн нийт зардал 3,3 дахин өсч, төсвийн зарлагын өсөлт ДНБ-ний өсөлтөөс давж байна.

ДНБ-ний жил бүрийн өсөлтөөс нэгдсэн төсвийн нийт зарлагын жил бүрийн өсөлт 6,7 пунктээр давж байна. Энэ нь ЗГ-ын зардал эдийн засгийн өсөлтөөс түрүүлсэн зохисгүй байдлыг үүсгэж байна. 2008 онд манай улсын ДНБ-д нэгдсэн төсвийн зарлагын эзлэх хувь 40,2 хувьд хүрч өмнөх жилүүдийнхээс эрс нэмэгджээ.

Иймд ДНБ-ний өсөлтөөс төсвийн зарлагын өсөлт түрүүлэхгүй байх зарчмыг цаашид мөрдөх, ЗГ-ын зардлыг багасгаж, төсвийн нэгдсэн болон урсгал зардлын ДНБ-нд эзлэх хэмжээнд тодорхой хязгаар тогтоох шаардлагатай байна.

Улсын төсвийн зардал төлөвлөгөөнөөс хэмнэгдсэн боловч өмнөх онтой харьцуулахад урсгал зардал 7,4 хувиар, 2004 онтой харьцуулахад 2,7 дахин өссөн байна.

- *Зардал хоорондын шилжүүлэг.* Сангийн сайдын 2005 оны 123 дугаар тушаалаар зардлыг эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахаар гаргасан саналыг хянаж, батлагдсан хөрөнгийн дүнд багтаан санхүүжилтэд нь зохицуулалт хийх эрхийг Төрийн сангийн газарт олгосон байна. Тушаалын дагуу 3.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийн зориулалтыг өөрчлөн зардал хооронд шилжүүлэн зарцуулжээ.

Түлш халаалтын зардлаас 408.7 сая, үрийн нөөц бэлтгэх зардлаас 216.9 сая, холбооны суваг ашигласны төлбөрөөс 185.0 сая, тээвэр шатахуунаас 182.6 сая, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлээс 114.6 сая, хоолны зардлаас 104.8 сая төгрөгийг зардал хооронд шилжүүлж зарцуулсан байна.

Энэ нь цаашид төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулах шаардлагатайг харуулж байна.

3.3. Төсвийн ерөнхийлөн захирагчдын 2008 оны зарлагын гүйцэтгэл

Төсвийн ерөнхийлөн захирагчдын зардлын гүйцэтгэл. 2008 онд ТЕЗ-дын төсвийн зарлагын гүйцэтгэл 1751.8 тэрбум төгрөгт хүрч 70.1 тэрбум төгрөгийг хэмнэжээ.³

2008 оны Төсвийн тухай хуулиар батлагдсан төсвийг 4 ТЕЗ хэтрүүлэн зарцуулжээ. Үүнийг хүснэгтээр харуулав.

Төсвийн ерөнхийлөн захирагч	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая.төгрөгөөр/	
			Зөрүү	Хувь
Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	47 456,8	48 352,0	895,2	101,9
Үйлдвэр, худалдааны сайд	1 950,5	2 084,4	133,9	106,9
Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз	9 401,2	9 742,7	341,5	103,6
Санхүүгийн зохицуулах хороо	620,6	743,4	122,8	119,8

- *Зардлын шилжүүлэг.* Төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт төсөв хэтрээгүй ч багц дотроо 50 байгууллага 6,7 тэрбум төгрөгөөр төсөв хэтрүүлэн зарцуулсан байна.

- *Ажиллагсадтай холбогдсон зардлын санхүүжилт.* 2008 онд ТЕЗ-дын цалингийн зардал 497.2 тэрбум төгрөгт хүрч өнгөрсөн оноос 80.4 хувиар буюу 221.6 тэрбум төгрөгөөр өсчээ.

³ ТЕЗ-дын 2008 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийг хавсралт 3-т үзүүлэв.

ТЕЗ-дын цалин нэмэгдлийн өсөлтийн судалгаа

Үзүүлэлт	(тэрбум төгрөгөөр)		
	2004 он гүйцэтгэл	2007 он гүйцэтгэл	2008 он гүйцэтгэл
Цалин, нэмэгдэл	119.4	275.6	497.2
Өсөлтийн дүн (өмнөх оноос)		1,5 дахин	1,8 дахин
Өсөлтийн хурд		2,3 дахин	4,1 дахин

ТЕЗ-дын цалин, нэмэгдлийн дүн 2004-2008 онд 4,1 дахин өсч, 2008 онд өмнөх оноос 1,8 дахин өсчээ.

Эндээс үзвэл цалин, нэмэгдлийн өсөлт сүүлийн хоёр жилүүдэд илүү хурдацтай явагдаж ирсэн байна.

2008 онд БСШУС-ын багц 4,6 тэрбум, ЭМС-ын багц 1,5 тэрбум, УИХТГ 0,6 тэрбум, НХХС-ын багц 0,2 тэрбум төгрөгөөр, нийт 9,3 тэрбум төгрөгөөр цалингийн зардлыг хэмнэсэн байна.

Энэ нь батлагдсан орон тоонд хүнээ бүрэн авч ажиллуулаагүй болон тухайн зардлыг төлөвлөх арга зүй боловсронгуй бусаас шалтгаалжээ. Дээрх хэмнэсэн зардлыг төрийн албан хаагчийн дундаж цалингаар тооцоход 2572 албан хаагчийг бүтэн жил цалинжуулах хэмжээний зардал юм.

- *Бараа үйлчилгээний бусад зардал.* Бараа, үйлчилгээний бусад зардал тайлант хугацаанд нийт дүнгээрээ хэтрээгүй ч 13 ТЕЗ-ийн багц 2,9 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна. Хүснэгтээр харуулав:

№	Багцын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөгөөр/	
				Хэтрэлт	Хувь
1	Шүүхийн ерөнхий зөвлөл	1704,28	1799,95	(95,67)	105.6
2	Улсын Ерөнхий прокурор	963,43	1067,65	(104,22)	110.8
3	Монгол Улсын Шадар сайд	11184,33	11346,01	(161,67)	101.4
4	Хууль зүй дотоод хэргийн сайд	37412,91	37509,65	(96,73)	100.3
5	Боловсрол Соёл Шинжлэх ухааны сайд	135403,97	135430,06	(26,08)	100.0
6	Зам тээвэр, Барилга хот байгуулалтын сайд	7087,87	7719,45	(631,58)	108.9
7	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	5894,57	6443,40	(548,83)	109.3
8	Үйлдвэр, худалдааны сайд	1640,65	1776,26	(135,61)	108.3
9	Эрүүл мэндийн сайд	79212,52	79795,66	(583,14)	100.7
10	Санхүүгийн зохицуулах хороо	134,06	150,60	(16,53)	112.3
11	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга	121,96	143,22	(21,25)	117.4
12	Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз	5779,53	6259,19	(479,65)	108.3
13	Тэргүүн шадар сайд	1059,76	1087,28	(27,52)	102.6
Дүн		287599,90	290528,44	(2928,53)	

Төрийн сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаж буй эдийн засгийн ангилал, Сангийн сайдын 2005 оны 276 дугаар тушаалаар баталсан зардлын дансны ангилал, төсвийн төлөвлөгөө боловсруулж буй зардлын ангилал

хоорондоо зөрүүтэйгээс төсвийн гүйцэтгэлийн тайланд зардлын зүйл ангиуд хоорондоо гүйж тайлагнагджээ.

- *Өндөр насны болон ҮОМШӨ-ний тэтгэвэрт олгох татаас.* Улсын төсвөөс 173.4 тэрбум төгрөгийг Нийгмийн даатгалын санд олгожээ. Тус сангаас 93,5 хувь буюу 162.2 тэрбум төгрөгийг өндөр настны тэтгэвэрт, үлдэх 11.2 тэрбум төгрөгийг Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэрт тус тус зориулан олгожээ.

- *Нийгмийн халамжийн зардлын талаар.* 2008 онд нийгмийн халамжийн санд 258.8 тэрбум төгрөг зарцуулахаар батлагдсанаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж үйлчилгээ, хүн амын хөгжлийг дэмжих арга хэмжээ, Монгол Улсын хөгжүүлэх сангаас олгож байгаа хүүхдэд олгох мөнгөн тэтгэмжид нийт 212.8 тэрбум төгрөгийг олгосон байна.

- *Эрчим хүчний алдагдал нөхөх татаас.* Сангийн сайд, Түлш, эрчим хүчний сайдын 2006 оны 16/04 дугаар тушаалаар батлагдсан “Эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй аймгуудын эрчим хүчний үйлдвэрүүдийн алдагдлыг нөхөхөд төсвөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх” журмаар дизель станц ажиллуулж эрчим хүч үйлдвэрлэдэг Говь-Алтай, Завхан аймгуудын Эрчим хүчний үйлдвэрүүдэд санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр заасан байна. Тус журмыг зөрчиж Увс, Дорнод, Өмнөговь аймаг, Налайх, Багануур дүүргүүдэд санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Эрчим хүчний үйлдвэрүүдэд олгож буй татаасын хэмжээ

Үйлдвэрүүд		2006 он	2007 он	2008 он	2009 он(төл)
1	Говь-Алтай эрчим хүчний үйлдвэр	2652.1	2818.0	4701.1	6132.0
	Завхан эрчим хүчний үйлдвэр	2962.1	3055.0	4568.8	5240.7
	Дизелийн станцын алдагдлын татаасын дүн	5614.2	5873.0	9269.9	11372.7
2	Дорнод бүсийн эрчим хүчний системийн ХК	300.0	650.0	650.0	650.0
	Баруун бүсийн эрчим хүчний систем ХК	908.4	1354.0	2000.0	3300.0
	Цахилгаан дамжуулах системийн алдагдлын татаасын дүн	1208.4	2004.0	2650.0	3950.0
3	Даланзадгадын дулааны цахилгаан станц ХК	500.0	710.0	750.0	750.0
	Налайхын дулааны станц ХК	-	450.0	598.2	490.0
	Багануурын дулааны цахилгааны станц ХК	-	-	357.0	357.0
	Дулааны цахилгаан станцын алдагдалын татаасын дүн	500.0	1160.0	1705.2	1597.0
Нийт татаасын дүн		7322.6	9037.0	13625.1	16919.7

Үйлдвэрүүдийн санхүүгийн тайлангаар гарсан алдагдлыг аудитаар баталгаажуулж, олгосон татаастай эргэж тооцоо хийдэг гүйцэтгэлийн хяналт алга байна.

Д° д° а. З° аё° ì æ

Ерөнхий сайд С.Баярт:

1. Эрдэнэт ХХК, Улаанбаатар төмөрзам хувь нийлүүлсэн нийгэмлэг хамтарсан үйлдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлд Монгол Улсыг төлөөлж буй гишүүдэд Монгол Улсын хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар үүрэг өгч, биелэлтийг хангуулан, хариуцлага тооцож байх
2. Улсын төсвөөс авах нийгмийн даатгалын сангийн авлага, нэрийн дансны үлдэгдлийн тооцоог баталгаажуулах

Сангийн сайд С.Баярцогтод:

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг аккруэль суурьт шилжүүлэх боломжийг судалж, холбогдох арга хэмжээ авах
2. Сангийн яам, УНДЕГ-ын хооронд байгуулсан гэрээний дагуу Төрийн санд байршуулсан нийгмийн даатгалын сангийн харилцах дансны дундаж үлдэгдлийн хүүгийн орлогыг тооцож олгох
3. “Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай” хуулийн дагуу Монгол Улсыг хөгжүүлэх санд 2007 оны улсын төсвийн ашгийн дутуу 100.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлэх арга хэмжээ авах
4. Төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, зарлагын төлөвлөгөөг дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлттэй уялдуулан боловсронгуй болгож, батлагдсан төсөвт багтаан зарцуулах
5. Төсвийн Ерөнхийлөн захирагч нарын ирүүлж буй тохируулах бичилтийн тайланг хянаж, хүлээн авч байх
6. Эрчим хүчний үйлдвэрүүдэд татаас олгоход баримтлах журмыг боловсронгуй болгох, алдагдлыг баталгаажуулж, дотоод хяналтыг сайжруулах

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн төсвийг орон нутгийн төсөвт тусган төлөвлөж, тайлагнаж байх

МОНГОЛ УЛСЫН 2008 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Хавсралт №1

Төсвийн орлогын нэр	Орлогын нэгдсэн дүн				Үүнээс:				/сая төгрөгөөр/					
	төлөвлөгөө		эрүү		Улсын төсөв		Орон нутгийн төсөв		нийгмийн даатгалын сан		Монгол улсыг хөгжүүлэх сан			
	төлөвлөгөө	гүйцэтгэл	эрүү	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл	төлөвлөгөө	гүйцэтгэл		
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,504,971.2	2,170,370.1	(334,601.1)	1,720,320.5	1,463,943.7	(256,376.8)	202,310.3	202,494.3	471,360.9	456,394.8	(12,966.1)	463,605.1	385,706.4	(77,898.7)
А. УРСГАЛ ОРЛОГЫН ДҮН	2,485,028.4	2,151,049.9	(333,978.5)	1,610,883.1	1,364,731.1	(246,152.0)	169,873.7	171,259.1	297,896.1	284,930.0	(12,966.1)	463,605.1	384,847.3	(78,757.8)
1. Татварын орлого	2,134,184.4	1,890,896.7	(243,287.7)	1,279,716.5	1,126,244.5	(153,472.0)	150,414.3	150,451.6	297,896.1	284,930.0	(12,966.1)	463,605.1	384,847.3	(78,757.8)
1.1 Орлогын албан татвар	888,797.7	754,839.9	(133,957.8)	413,968.5	355,115.6	(58,852.9)	11,224.2	14,877.0	3,652.8			463,605.1	384,847.3	(78,757.8)
1.1.1 Хувь хүний орлогын	97,858.0	116,712.7	18,854.7	91,789.0	101,889.1	10,190.1			-					
1.1.2 ААН, байгууллагын	327,334.6	253,279.9	(74,054.7)	327,334.6	253,279.9	(74,054.7)			-			463,605.1	384,847.3	(78,757.8)
1.1.3 Бүтээгдэхүүний үнийн өсөлтийн	463,605.1	384,847.3	(78,757.8)						-					
1.2 Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	240,448.6	229,353.2	(11,095.4)						-	297,896.1	284,930.0	(12,966.1)		
1.3 Өнчийн татвар	8,737.7	9,199.3	461.6					9,199.3	461.6					
1.4 Нэмэлдсэн өртгийн албан татвар	407,196.3	368,049.5	(39,146.8)	377,472.4	338,325.6	(39,146.8)	29,723.9	29,723.8	(0.1)					
1.5 Онцгой албан татвар	193,186.5	178,466.9	(14,719.6)	193,186.5	178,466.9	(14,719.6)								
1.6 Тусгай зориулалтын орлого	16,430.8	15,501.8	(929.0)	9,014.5	7,891.9	(1,122.6)	7,416.3	7,609.9	193.6					
1.7 Гаалийн албан татвар	159,495.2	140,838.7	(18,656.5)	159,495.2	140,838.7	(18,656.5)								
1.8 Бусад татвар	219,891.6	194,647.4	(25,244.2)	126,579.4	105,605.8	(20,973.6)	93,312.2	89,041.6	(4,270.6)					
2.2 Татварын бус орлого	350,844.0	260,153.2	(90,690.8)	331,166.6	238,486.6	(92,680.0)	19,459.4	20,807.5	1,348.1	-	-	463,605.1	384,847.3	(78,757.8)
Б. ХӨРӨНГИЙН ОРЛОГО	4,127.8	3,201.6	(926.2)	109,437.4	99,212.6	(10,224.8)	25,878.3	28,033.6	2,155.3	173,464.8	-	-	859.1	-
В. ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	15,815.0	16,118.6	303.6	(5,165.1)	(5,165.1)	-	5,011.7	-	-	-	-	-	-	-
Г. ХХОАТ-ын буцаан олголт				(5,165.1)	(5,165.1)	-	5,011.7	-	-	-	-	-	-	-
Д. НӨАТ-ын буцаан олголт				(29,723.9)	(29,723.9)	-	0.1	-	-	-	-	-	-	-
Е. НӨАТ-ын орон нутгийн шилжүүлэг				463,410.9	427,830.2	(35,580.7)	2,430.5	-	-	-	-	-	-	-
Е. НӨАТ-ын албан татварын дүн														
Ж. Оны эхний үлдэгдэл							2,430.5	-	-	-	-	-	-	-

Хавсралт № 2

МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН 2008 ОНЫ ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

Үзүүлэлт	НЭГДСЭН ТӨСӨВ		Зөрүү	УЛСЫН ТӨСӨВ		Зөрүү	ОРОН НУТАГ		Зөрүү	МУХС		Зөрүү	НДС		Зөрүү
	Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц		Төлөв	Гүйц	
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2 532 158.6	2 466 774.4	-65 384.2	1 815 584.4	1 745 484.3	-70 100.1	212 118.4	203 315.8	-8 802.6	435 745.2	438 238.8	2 493.6	420 446.8	419 904.6	-542.2
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2 458 592.8	2 385 580.3	-73 012.4	1 742 018.6	1 664 290.3	-77 728.4	212 118.4	203 315.8	-8 802.6	435 745.2	438 238.8	2 493.6	420 446.8	419 904.6	-542.2
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1 827 020.0	1 761 190.6	-65 829.4	1 459 812.5	1 415 475.2	-44 337.3	166 061.2	159 167.6	-6 893.6	135 100.8	109 555.4	-25 545.4	417 781.8	417 161.5	-620.4
Бараа, үйлчилгээний зардал	1 066 050.0	1 054 940.0	-11 110.0	998 280.4	983 320.4	-14 960.0	96 356.0	99 795.9	3 439.9	0.8	1.3	0.5	19 903.1	19 274.1	-629.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	555 317.8	544 450.3	-10 867.6	506 460.5	497 202.0	-9 258.5	42 853.4	41 509.9	-1 343.5	0.0	0.0	0.0	6 004.0	5 738.4	-265.6
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэ	48 490.3	47 451.7	-1 038.5	43 591.4	42 701.9	-889.4	4 298.5	4 144.3	-154.2	0.0	0.0	0.0	600.4	605.4	5.0
Бараа, үйлчилгээний бусад зардал	510 732.2	510 489.8	-242.4	448 228.6	443 416.5	-4 812.1	49 204.1	54 141.7	4 937.6	0.8	1.3	0.5	13 298.7	12 930.3	-368.4
Зээлийн үйлчилгээ (хүү)	20 447.4	19 949.0	-498.4	20 447.4	19 949.0	-498.4	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Татаас ба урсгал шилжүүлэг	740 522.5	686 301.5	-54 221.0	441 084.6	412 205.8	-28 878.8	69 705.1	59 371.6	-10 333.5	135 100.0	109 554.1	-25 545.9	397 878.8	397 887.4	8.6
Татаас	293 833.7	286 514.4	-7 319.3	211 669.0	210 063.3	-1 605.8	11 567.1	11 601.1	34.0	30 500.0	24 580.4	-5 919.6	40 097.6	40 269.7	172.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	631 572.8	624 389.8	-7 183.0	282 206.2	248 815.1	-33 391.1	46 057.2	44 148.2	-1 909.0	300 644.4	328 683.3	28 038.9	2 665.0	2 743.1	78.1
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР Э	73 565.8	81 194.0	7 628.3	73 565.8	81 194.0	7 628.3	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0	0.0
Төсвийн гэнцэл	658 008 338	389 859 198	-268 149 140	151 070 580	-50 744 057	-201 814 637									
УРСГАЛ	-27 187 397	-296 404 378	-269 216 981	-95 263 926	-281 540 580	-186 276 654									
НИЙТ															

сая.төгрөгөөр

Хавсралт 3

ТЕЗ-дын 2008 оны төсвийн зарлагын гүйцэтгэлийн судалгаа

№	Эдийн засгийн ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая.төгрөгөөр/	
				Зөрүү	Хувь
	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1 822 013,0	1 751 870,6	- 70 142,4	96,2
1	Монгол Улсын Ерөнхийлөгч	1 924,1	1 758,3	-165,8	91,4
2	Монгол Улсын Их Хурал	7 501,7	6 615,5	-886,2	88,2
3	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц	746,1	734,2	-11,9	98,4
4	Улсын Дээд шүүх	957,7	939,8	-17,9	98,1
5	Шүүхийн ерөнхий зөвлөл	12 325,3	12 321,0	-4,3	100,0
6	Улсын Ерөнхий прокурор	7 502,0	7 494,7	-7,3	99,9
7	Монгол Улсын Ерөнхий сайд	18 256,7	17 490,1	-766,6	95,8
8	Монгол Улсын Шадар сайд	57 620,7	57 381,9	-238,8	99,6
9	Тэргүүн шадар сайд	7 365,4	6 834,1	-531,3	92,8
10	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	12 357,2	11 803,5	-553,7	95,5
11	Гадаад харилцааны сайд	22 555,7	19 493,2	-3 062,5	86,4
12	Сангийн сайд	175 973,5	182 597,0	6 623,5	103,8
13	Хууль зүй, дотоод хэргийн сайд	156 868,2	156 708,4	-159,8	99,9
14	Байгаль орчин, Аялал жуулчлалын сайд	26 282,1	25 889,0	-393,1	98,5
15	Батлан хамгаалахын сайд	67 339,7	66 614,0	-725,7	98,9
16	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд	425 238,3	414 243,6	-10 994,7	97,4
17	Зам тээвэр, аялал жуулчлалын сайд	701,6	568,6	-133,0	81,0
18	Барилга, хот байгуулалтын сайд	99 834,0	73 097,0	-26 737,0	73,2
19	Эрдэс баялаг, эрчим хүчний сайд	47 456,8	48 352,0	895,2	101,9
20	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд	355 557,1	328 229,8	-27 327,3	92,3
21	Үйлдвэр, худалдааны сайд	1 950,5	2 084,4	133,9	106,9
22	Эрүүл мэндийн сайд	213 504,1	211 669,2	-1 834,9	99,1
23	Сонгуулийн Ерөнхий хороо	5 633,9	5 546,3	-87,6	98,4
24	Хүний эрхийн үндэсний комисс	269,5	264,7	-4,8	98,2
25	Үндэсний аудитын газар	554,2	539,3	-14,9	97,3
26	Санхүүгийн зохицуулах хороо	620,6	743,4	122,8	119,8
27	Үндэсний статистикийн газар	2 491,4	2 482,7	-8,7	99,7
28	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах комисс	658,8	509,4	-149,4	77,3
29	Төрийн албаны зөвлөлийн дарга	307,7	278,4	-29,3	90,5
30	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дарга	440,9	440,5	-0,4	99,9
31	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч	9 322,3	8 546,5	-775,8	91,7
32	Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз	9 401,2	9 742,7	341,5	103,6
33	Хүнс, хөдөө аж ахуй, Хөнгөн үйлдвэрийн сайд	69 640,2	67 236,0	-2 404,2	96,5
34	Авилгатай тэмцэх газар	2 853,1	2 621,1	-232,0	91,9

Хавсралт 4

Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдын
2008 оны төсвийн зарлагын гүйцэтгэл

/ сая төгрөгөөр/

№	АЙМАГ, НИЙСЛЭЛ	2007 оны гүйцэтгэл	ТӨСВИЙН ЗАРЛАГА				
			Батлагдсан төлөвлөгөө	Аудит хийгдсэн төлөвлөгөө	2008 он Гүйцэтгэл	зөрүү	хувь
1	Архангай	3,239.4	4 735,60	4 735,60	4 962,60	227	104,8
2	Баян-Өлгий	2,706.7	3 915,90	3 915,90	4 049,20	133,3	103,4
3	Баянхонгор	3,358.6	4 730,30	4 730,30	4 989,80	259,5	105,5
4	Булган	3,280.9	4 763,00	4 763,00	4 619,30	-143,7	97
5	Говь-Алтай	3,487.8	4 980,80	4 980,80	4 916,20	-64,6	98,7
6	Дорноговь	3,475.3	5 373,40	5 373,40	5 795,40	422	107,9
7	Дорнод	2,686.8	4 437,70	4 437,70	4 235,80	-201,9	95,5
8	Дундговь	2,653.1	3 486,70	3 486,70	3 505,90	19,2	100,6
9	Завхан	3,546.5	4 588,90	4 588,90	4 738,50	149,6	103,3
10	Өвөрхангай	3,782.4	5 363,20	5 363,20	5 363,20	-	100
11	Өмнөговь	5,274.4	9 239,70	9 239,70	9 276,20	36,5	100,4
12	Сүхбаатар	3,529.5	4 213,80	4 213,80	4 148,30	-65,5	98,4
13	Сэлэнгэ	3,577.2	7 116,80	7 116,80	7 257,90	141,1	102
14	Төв	5,412.0	7 775,70	7 775,70	7 473,50	-302,2	96,1
15	Увс	3,336.8	4 548,40	4 548,40	4 736,50	188,1	104,1
16	Ховд	3,446.0	4 545,00	4 545,00	4 641,10	96,1	102,1
17	Хөвсгөл	4,199.3	5 448,50	5 448,50	5 714,50	266	104,9
18	Хэнтий	3,577.3	4 567,00	4 567,00	4 208,60	-358,4	92,2
19	Дархан-Уул	2,924.0	4 148,80	4 148,80	4 322,20	173,4	104,2
20	Улаанбаатар	47,170.4	53 155,80	54 010,80	53 623,80	468	100,9
21	Орхон	5,749.8	5 518,90	5 518,90	6 108,40	589,5	110,7
22	Говь-Сүмбэр	1,212.7	1 939,20	1 939,20	1 804,10	-135,1	93
	ДҮН	121,626.8	158 593,10	159 447,30	160 491,00	-1 043,7	



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 17 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Санхүүгийн аудитын тайланг
баталгаажуулах тухай

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 38.1, Төрийн аудитын тухай хуулийн 18.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Засгийн газрын 2008 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Монгол Улсын 2008 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлангуудыг баталсугай.

Хоёр.Аудитын явцад тогтоосон төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд нарт хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2010 оны 1 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт танилцуулахыг Сангийн сайдад зөвлөсүгэй.

Тав.Аудитын зөвлөмжийн биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Нэгдүгээр газрын захирал Ц.Батбаярт даалгасугай.



Ч.Раднаа

Ч.РАДНАА

070033

tushaal